**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

**Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

**Аудитын код:** УВА-2023/35/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2023 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Б.Одгэрэл<br>Утас: 86032989, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ..........
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ..........
3. Санхүүгийн тайлангийн тодруулга..........
   3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа..........
   3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..........
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..........
   3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт ..........
4. Аудитын тайлан..........
   4.1 Ерөнхий зүйл ..........
   4.2 Материаллаг байдал ..........
   4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт..........
   4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..........
   4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..........
   4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..........
5. Аудитын илрүүлэлт ..........
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл..........

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |

**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17. Факс: (976)70-45-33-17.
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.14 № УВА-2023/35/НА-СТА-ТШ3

танай ______ -ны № ______ -т

УВС АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫНАЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.ПҮРЭВГОНЧИГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

0000006470

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөг/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **52,650,655.00** | **59,186,555.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **0.00** | **0.00** |
| **31200** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **0.00** | **0.00** |
| **31210** | **Төгрөг** | **0.00** | **0.00** |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 0.00 | 0.00 |
| **33** | **АВЛАГА** | **0.00** | **0.00** |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 0.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **52,650,655.00** | **59,186,555.00** |
| **35100** | **Түүхий эд материал** | **33,192,005.00** | **33,127,005.00** |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 33,192,005.00 | 33,127,005.00 |
| **35400** | **Хангамжийн материал** | 19,458,650.00 | 26,059,550.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 774,800.00 | 884,100.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,197,100.00 | 15,170,000.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,579,500.00 | 3,579,500.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 5,907,250.00 | 6,425,950.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **2,359,053,150.39** | **2,274,968,174.90** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **2,359,053,150.39** | **2,274,968,174.90** |
| **39200** | **Биет хөрөнгө** | **2,041,733,150.39** | **1,957,648,174.90** |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,963,420,300.00 | 1,963,770,300.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -401,220,637.48 | -448,268,257.30 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 108,200,000.00 | 108,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -52,379,166.68 | -64,829,166.68 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 338,851,684.00 | 325,548,684.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -258,449,195.07 | -269,839,267.15 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 81,264,554.90 | 84,946,554.90 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -57,954,389.28 | -61,880,672.87 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 320,000,000.00 | 320,000,000.00 |
| **39300** | **Биет бус хөрөнгө** | **317,320,000.00** | **317,320,000.00** |
| 39301 | Програм хангамж | 2,520,000.00 | 2,520,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,020,000.00 | -1,020,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 315,820,000.00 | 315,820,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | 0.00 | 0.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **2,411,703,805.39** | **2,334,154,729.90** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **1,185,000.00** | **390,168.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **1,185,000.00** | **390,168.00** |
| **41300** | **Өглөг** | **1,185,000.00** | **390,168.00** |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 0.00 | 0.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.00 | 390,168.00 |
| **41360** | **Бусад өглөг** | **1,185,000.00** | **0.00** |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,185,000.00 | 0.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **2,410,518,805.39** | **2,333,764,561.90** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **2,410,518,805.39** | **2,333,764,561.90** |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 3,567,962,432.24 | 3,567,962,432.24 |
| 51101 | Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 3,567,962,432.24 | 3,567,962,432.24 |
| **51200** | **Хуримтлагдсан үр дүн** | **-1,217,714,567.94** | **-1,294,468,811.43** |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -1,217,714,567.94 | -1,217,714,567.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | -198,997,371.48 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 60,270,941.09 | 60,270,941.09 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **2,411,703,805.39** | **2,334,154,729.90** |

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **629,689,520.82** | **856,242,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,485,520.82** | **350,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **6,485,520.82** | **350,000.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **6,485,520.82** | **350,000.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,095,000.00 | 0.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 2,390,520.82 | 350,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **623,204,000.00** | **855,892,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **280,392,400.00** | **439,929,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 280,392,400.00 | 439,929,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **13,224,000.00** | **56,240,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 42,370,000.00 |
| | | 11,674,000.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,550,000.00 | 13,870,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **329,587,600.00** | **359,722,600.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 329,587,600.00 | 359,722,600.00 |
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **718,052,639.58** | **932,096,443.49** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **718,052,639.58** | **932,096,443.49** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **711,645,633.95** | **887,845,724.04** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **217,365,695.00** | **240,004,386.79** |
| 210101 | Үндсэн цалин | 217,365,695.00 | 240,004,386.79 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,584,285.37** | **29,482,877.76** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,996,125.59 | 20,133,618.37 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,234,838.14 | 2,384,538.71 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,787,870.52 | 1,907,630.96 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 412,750.10 | 459,735.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,152,701.02 | 4,597,354.27 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **318,900,438.00** | **316,018,428.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,707,521.00 | 10,268,214.00 |
| 210302 | Түлш, халаалт | 312,065,600.00 | 302,326,453.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,127,317.00 | 3,423,761.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **7,104,052.00** | **13,080,000.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 756,700.00 | 1,226,150.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,155,970.00 | 3,666,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,008,582.00 | 1,032,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,830,000.00 | 1,080,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,352,800.00 | 6,075,350.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **9,629,550.00** | **20,598,950.00** |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 110,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 9,519,550.00 | 20,598,950.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **936,000.00** | **3,243,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 936,000.00 | 3,243,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,051,400.00** | **8,769,356.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,051,400.00 | 4,239,640.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 876,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 193,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 165,536.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 0.00 | 474,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 0.00 | 2,732,680.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **125,074,213.58** | **256,648,725.49** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 27,016,300.00 | 167,971,250.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 1,460,500.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 98,057,913.58 | 87,216,975.49 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,407,005.63** | **44,250,719.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,210,000.00** | **42,077,180.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 37,558,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,210,000.00 | 4,519,180.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,100,893.63** | **1,928,297.19** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,100,893.63 | 1,928,297.19 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **96,112.00** | **245,242.26** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 96,112.00 | 245,242.26 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **-88,363,118.76** | **-75,854,243.49** |
| **V** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | **33,880,009.23** | **900,000.00** |
| 225001 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз | 880,724.47 | 0.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 32,999,284.76 | 900,000.00 |
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН** | -33,880,009.23 | -900,000.00 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)** | **-122,243,127.99** | **-76,754,243.49** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **627,299,000.00** | **855,892,200.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **4,095,000.00** | **0.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **4,095,000.00** | **0.00** |
| **120004** | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **4,095,000.00** | **0.00** |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 4,095,000.00 | 0.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **623,204,000.00** | **855,892,200.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | **280,392,400.00** | **439,929,600.00** |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 280,392,400.00 | 439,929,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **13,224,000.00** | **56,240,000.00** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 0.00 | 42,370,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид | 11,674,000.00 | 0.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,550,000.00 | 13,870,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **329,587,600.00** | **359,722,600.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 329,587,600.00 | 359,722,600.00 |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **627,299,000.00** | **855,892,200.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **627,299,000.00** | **855,892,200.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **620,697,994.37** | **811,641,480.55** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **217,365,695.00** | **239,936,902.24** |
| 210101 | Үндсэн цалин | 217,365,695.00 | 169,383,533.67 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 34,248,271.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 20,745,000.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 15,560,096.91 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **27,584,285.37** | **29,550,362.31** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 19,484,466.07 | 20,304,519.24 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,172,791.24 | 2,396,705.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,738,232.95 | 1,917,364.19 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 374,308.67 | 448,343.03 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,814,486.44 | 4,483,430.61 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **318,900,438.00** | **315,628,260.00** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,707,521.00 | 9,878,046.00 |
| 210302 | Түлш, халаалт | 312,065,600.00 | 302,326,453.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,127,317.00 | 3,423,761.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **9,839,952.00** | **14,286,550.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 850,600.00 | 1,343,450.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,155,970.00 | 3,700,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,008,582.00 | 1,032,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,830,000.00 | 1,080,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,994,800.00 | 7,130,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | **370,000.00** | **0.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 370,000.00 | 0.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **10,791,050.00** | **25,173,850.00** |
| 210602 | Тавилга | 0.00 | 3,682,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 200,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 10,591,050.00 | 25,173,850.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **936,000.00** | **2,851,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 936,000.00 | 2,851,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **8,426,674.00** | **8,769,356.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,857,840.00 | 4,239,640.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 0.00 | 876,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 193,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 0.00 | 165,536.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 0.00 | 88,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,500,000.00 | 474,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 4,068,834.00 | 2,732,680.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **26,483,900.00** | **171,763,200.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,483,900.00 | 170,118,700.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 0.00 | 1,644,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **6,601,005.63** | **44,250,719.45** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **3,404,000.00** | **42,077,180.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 0.00 | 37,558,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 3,404,000.00 | 4,519,180.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **3,100,893.63** | **1,928,297.19** |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,100,893.63 | 1,928,297.19 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **96,112.00** | **245,242.26** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 96,112.00 | 245,242.26 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)** | **1,500,000.00** | **3,682,000.00** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **1,500,000.00** | **3,682,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,500,000.00** | **3,682,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **1,500,000.00** | **3,682,000.00** |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,500,000.00 | 3,682,000.00 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)** | **-1,500,000.00** | **-3,682,000.00** |
| | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | | |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,567,962,432.24** | **61,829,491.20** | **-1,097,029,990.06** | **2,532,761,933.38** |
| C02 | **Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт** | **0.00** | **0.00** | **1,558,550.11** | **1,558,550.11** |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,567,962,432.24** | **61,829,491.20** | **-1,095,471,439.95** | **2,534,320,483.49** |
| C04 | **Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт** | **0.00** | **-1,558,550.11** | **0.00** | **-1,558,550.11** |
| C05 | **Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| C06 | **Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| C07 | **Өмчид гарсан өөрчилөлт** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| C08 | **Зарласан ногдол ашиг** | **0.00** | **0.00** | **0.00** | **0.00** |
| D01 | **Тайлант үеийн үр дүн** | **0.00** | **0.00** | **-122,243,127.99** | **-122,243,127.99** |
| D02 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **3,567,962,432.24** | **60,270,941.09** | **-1,217,714,567.94** | **2,410,518,805.39** |
| D03 | **2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **3,567,962,432.24** | **60,270,941.09** | **-1,217,714,567.94** | **2,410,518,805.39** |
| D04 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 3,567,962,432.24 | 60,270,941.09 | -1,217,714,567.94 | 2,410,518,805.39 |
| | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **3,567,962,432.24** | **60,270,941.09** | **-1,217,714,567.94** | **2,410,518,805.39** |
| D05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D06 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D07 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | 0.00 | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | -76,754,243.49 | -76,754,243.49 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **3,567,962,432.24** | **60,270,941.09** | **-1,294,468,811.43** | **2,333,764,561.90** |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөг/

| ЭЗА | Үзүүлэлт | Тайлант оны | | |
|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 799,652,200.00 | 797,478,660.55 | 2,173,539.45 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 799,652,200.00 | 797,478,660.55 | 2,173,539.45 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 760,629,200.00 | 75,845,566.55 | 2,173,539.45 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 240,154,300.00 | 239,936,902.24 | 217,397.76 |
| 210101 | Үндсэн цалин | 169,613,300.00 | 169,383,533.67 | 229,766.33 |
| 210102 | Нэмэгдэл | 36,537,300.00 | 34,248,271.66 | 2,289,028.34 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 18,900,000.00 | 20,745,000.00 | (1,845,000.00) |
| 210104 | Урамшуулал | 15,103,700.00 | 15,560,096.91 | (456,396.91) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 30,019,100.00 | 29,550,362.31 | 468,737.69 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 20,413,200.00 | 20,304,519.24 | 108,680.76 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,401,400.00 | 2,396,705.24 | 4,694.76 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,921,200.00 | 1,917,364.19 | 3,835.81 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 480,200.00 | 448,343.03 | 31,856.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,803,100.00 | 4,483,430.61 | 319,669.39 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 315,443,600.00 | 315,443,600.00 | 0.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 8,497,000.00 | 9,693,386.00 | (1,196,386.00) |
| 210302 | Түлш, халаалт | 302,326,600.00 | 302,326,453.00 | 147.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,620,000.00 | 3,423,761.00 | 1,196,239.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 9,594,100.00 | 9,591,050.00 | 3,050.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,372,800.00 | 1,343,450.00 | 29,350.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,860,000.00 | 2,846,500.00 | 13,500.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,464,300.00 | 1,032,000.00 | 432,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 572,000.00 | 360,000.00 | 212,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,325,000.00 | 4,009,100.00 | (684,100.00) |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,739,000.00 | 23,738,990.00 | 10.00 |
| 210604 | Урсгал засвар | 23,739,000.00 | 23,738,990.00 | 10.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 3,325,000.00 | 2,851,000.00 | 474,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 3,325,000.00 | 2,851,000.00 | 474,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 6,655,000.00 | 5,938,556.00 | 716,444.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,437,000.00 | 1,408,840.00 | 28,160.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 876,000.00 | 876,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 450,000.00 | 193,500.00 | 256,500.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 165,536.00 | 84,464.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 110,000.00 | 88,000.00 | 22,000.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 500,000.00 | 474,000.00 | 26,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,032,000.00 | 2,732,680.00 | 299,320.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 131,699,100.00 | 131,405,200.00 | 293,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 129,797,100.00 | 129,760,700.00 | 36,400.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,902,000.00 | 1,644,500.00 | 257,500.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 39,023,000.00 | 39,023,000.00 | 0.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 39,023,000.00 | 39,023,000.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 38,023,000.00 | 37,558,000.00 | 465,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 1,465,000.00 | (465,000.00) |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 799,652,200.00 | 799,652,200.00 | 0.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 439,929,600.00 | 439,929,600.00 | 0.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 439,929,600.00 | 439,929,600.00 | 0.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 359,722,600.00 | 359,722,600.00 | 0.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 359,722,600.00 | 359,722,600.00 | 0.00 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | | | |
| 610001 | Төсвийн байгууллага | | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23.00 | 22.00 | |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 9.00 | 13.00 | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 13.00 | 8.00 | |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/төгрөг/**

| ЭЗА | Үзүүлэлт | Батлагдсан төлөвлөгөө | Тайлант оны | |
|---|---|---|---|---|
| | | | **Гүйцэтгэл** | **Зөрүү** |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | | **56,240,000.00** | **(56,240,000.00)** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **56,240,000.00** | **(56,240,000.00)** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | 53,185,820.00 | **(53,185,820.00)** |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | | 184,660.00 | **(184,660.00)** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | | 184,660.00 | **(184,660.00)** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | 4,695,500.00 | **(4,695,500.00)** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 854,000.00 | **(854,000.00)** |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 720,000.00 | **(720,000.00)** |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | | 3,121,500.00 | **(3,121,500.00)** |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | 5,116,860.00 | **(5,116,860.00)** |
| 210602 | Тавилга | | 3,682,000.00 | **(3,682,000.00)** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | | 1,434,860.00 | **(1,434,860.00)** |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | 2,830,800.00 | **(2,830,800.00)** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 2,830,800.00 | **(2,830,800.00)** |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | 40,358,000.00 | **(40,358,000.00)** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 40,358,000.00 | **(40,358,000.00)** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | 3,054,180.00 | **(3,054,180.00)** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 3,054,180.00 | **(3,054,180.00)** |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | 56,240,000.00 | **(56,240,000.00)** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | 56,240,000.00 | **(56,240,000.00)** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 42,370,000.00 | **(42,370,000.00)** |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 13,870,000.00 | **(13,870,000.00)** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Биеийн тамир, спортын газар нь идэвхтэй хөдөлгөөнөөр хичээллэх, эрүүл мэндээ хамгаалах, сайжруулах нөхцөлийг бүрдүүлж, олон нийтэд хүртээмжтэй болгох, спортын сургалт дасгалжуулалтын үр дүнд тулгуурлан өсвөрийн шигшээ багийн тамирчдыг бэлтгэх, тамирчдын амжилтыг тив, дэлхий, олимпын түвшинд хүргэх үйл ажиллагааг явуулдаг байгууллага юм
“Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгож, мэргэжлийн спортыг дэмжиж, тамирчдын тив, дэлхий, олимпийн түвшинд өрсөлдөх чадвар, амжилтыг нэмэгдүүлж, биеийн тамир, спортын чанар, хүртээмж, үр дүнг сайжруулна” гэсэн зорилгын дор 4 зорилт 37 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг болсон байна. Үйл ажиллагаандаа Төрийн албан тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Биеийн тамир, спортын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 5 дугаар тогтоол, Сангийн сайд, Эрүүл мэндийн сайдын 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн хамтарсан 53/45 тоот тушаал, Засгийн газрын тогтоол, шийдвэр болон аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, Засаг даргын захирамж, албан даалгавар, байгууллагын дотоод журам, биеийн тамир, спортын газрын дүрмийг хэрэгжүүлж ажилладаг.

Тайлант хугацаанд санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр

- ✓ Засгийн газрын 2018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам"
- ✓ Засгийн газрын 2019 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн 276 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт
- ✓ Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолын 7 дугаар хавсралт
- ✓ Сангийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн 120 дугаар "Албан томилолтын зардлын тариф шинэчлэн батлах тухай" тушаалд тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл суурьиар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж болон, нягтлан бодох бүртгэлийн стандарт бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 77,549.0 мянган төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 52,650.7 | 59,186.6 | 6,535.9 |
| Үндсэн хөрөнгө | 2,359,053.2 | 2,274,968.2 | -84,085.0 |
| **Нийт хөрөнгө** | **2,411,703.8** | **2,334,154.7** | **-77,549.1** |

| | | | |
|---|---|---|---|
| Өр төлбөр | 1,185.0 | 390.2 | -794.8 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 2,410,518.8 | 2,333,764.6 | -76,754.2 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **2,411,703.8** | **2,334,154.7** | **-77,549.1** |

Тайлант оны эхэнд болон эцэст мөнгөн хөрөнгө, авлагын данс үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 59,186.6 мянган төгрөг болж 6,535.9 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуйн материал, бусад хангамжийн материалын худалдан авалт, зарцуулалтаас шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд худалдаж авсан ашиглалтгүй бараа материал байхгүй.

Үндсэн хөрөнгийн данс нь 2,274,968.2 мянган төгрөг болж 84,085.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр худалдан авсан 3,682.0 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан 350.0 мянга нийт 4,032.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, тайлант онд 87,217.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал тооцсон, балансаас балансад шилжүүлсэн 7,800.0 мянга, элэгдлээ бүрэн нөхөж, ашиглалтгүй болсон 5,503.0 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 390.1 мянган төгрөг болж 794.8 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны хувь хүмүүст төлөх өглөгийг барагдуулж, тайлант онд гэрэл цахилгааны өр төлбөр үүссэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,333,764.6 мянган төгрөг болж 76,754.2 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн буурсантай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 814,543.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 807,743.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас 83,429.2 мянган төгрөгөөр бууруулж 731,114.4 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулиас шалтгаалан эд хогшил худалдан авах зардал, уралдаан тэмцээн, арга хэмжээний зардлыг бууруулсантай холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 68,537.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон нь төрийн үйлчилгээний албан хаагчдын цалин, ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшууллын зардалтай холбоотой байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг улсын төсвөөс 439,929.6 мянга, орон нутгийн төсвөөс 359,722.6 мянга, нийт 799,652.2 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 799,652.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 797,478.7 мянган төгрөг зарцуулж, 2,173.5 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 797,478.7 мянган төгрөг буюу 99.7 хувьтай байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 71701,80101 | 272,061.2 | 270,169.4 | 1,891.8 | 99.3 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2 | 71701,80305 | 91,183.4 | 91,150.9 | 32.5 | 100 |
| 3 | 71701,82106 | 37,662.0 | 37,658.1 | 3.9 | 100 |
| 4 | 71701,80802 | 39,023.0 | 39,023.0 | 0.0 | 100 |
| 5 | 71701,80111 | 339,182.6 | 339,182.6 | 0.0 | 0 |
| 6 | 71701,80112 | 20,540.0 | 20,294.8 | 245.2 | 98.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгийн санхүүжилт 42,327.0 мянга, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон орлогоос 13,870.0 мянга, нийт 56,240.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, байр ашиглалттай холбоотой зардалд 184.7 мянга, хангамж, бараа материалын зардалд 4695.5 мянга, эд хогшил, урсгал засварын зардалд 5,116.9 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн болон бараа үйлчилгээний бусад зардалд 43,188.8 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Одгэрэл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 01/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож,

материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 5.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 932.1 сая төгрөгийн 1.0 хувь буюу 9.3 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 7.5 сая төгрөгөөр тогтоолоо.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллагад хамаарах зүйл заалтын хүрээнд биет горим сорилыг хэрэгжүүлсэн. /АБ-4/

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа 143, хугацаа хоцроосон 6 мэдээллийг байршуулсан, хугацаа болоогүй 2 мэдээлэл хүлээгдэж байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт "Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй" гэж заасныг Увс аймгийн Биеийн тамир, спортын газар нь тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Биеийн тамир, спортын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн акт, өгсөн албан шаардлага, зөвлөмж байхгүй.

**4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар алдаа зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

| | | |
|---|---|---|
| | ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР | [illegible].БАТСУУРЬ/ |
| | АУДИТЫН МЕНЕЖЕР | /М.БАТ-АМГАЛАН/ |
| БЭЛТГЭСЭН: | АУДИТОР | /Б.ОДГЭРЭЛ/ |

2023 оны 02 сарын 10-ны өдөр